



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/263

Ховд

Мал, амьтны шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх
арга хэмжээг хэрэгжүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "А" заалт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх заалтыг үндэслэн Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2020 оны А/76 дугаар тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтны шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээг Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын баталсан 05 дугаар удирдамж, шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн дагуу зохион байгуулахыг Мал эмнэлгийн газар /Д.Батцэнгэл/-т үүрэг болгосугай.

2. Энэхүү арга хэмжээг харьяалах нутаг дэвсгэртээ сумдын Засаг дарга, Мал эмнэлгийн тасаг, Мал эмнэлэг үйлчилгээний нэгжийн хооронд байгуулсан гурвалсан гэрээ болон түүний 2 дугаар хавсралтанд заасан төлөвлөгөөний дагуу зохион байгуулахыг сумдын Засаг дарга, Мал эмнэлгийн тасгийн дарга нарт даалгасугай.

3. Шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн газар /Д.Батцэнгэл/-т хариуцуулсугай.

ЗАСАГ ДАРГА



Б. ДҮГЭРЖАВ

Zax A/263 Ch

02 01141